САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2026.09.28 № 1/3637

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН П.НАРАНБАЯР ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн асуулгын хариуг хүргүүлж байна.

1. Санхүүгийн зохицуулах хороо Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасны дагуу банк бус санхүүгийн байгууллагаас санхүүгийн тайланг улирал бүр хүлээн авч, зайнаас эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлдэг. Энэхүү хяналтын хүрээнд эрсдэл өндөртэй болон санхүүгийн хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хөндлөнгийн бусад мэдээлэлд үндэслэн газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022-2026 оны эхний хагас жилийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудад хийсэн газар дээрх болон зайны хяналтын талаарх мэдээллийг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг нийт 574 банк бус санхүүгийн байгууллага ирүүлэхээс 523 буюу 91.1 хувь нь Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлснийг хүлээн авч, хянан баталгаажуулсан. Үүнээс 252 банк бус санхүүгийн байгууллага Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны цахим сайт /bbsb.mn/ https://bbsb.mn/2025-тайлан-ббсб/-аар, 271 банк бус санхүүгийн байгууллага өдөр тутмын сонин болон өөрсдийн цахим сайтаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажилласан байна.

3. 2026 оны эхний хагас жилийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн үлдэгдэл 8.2 их наяд төгрөг бөгөөд үүний 86.0 хувийг буюу 7.1 их наяд төгрөгийн хэвийн зээл, 4.7 хувийг буюу 390.2 тэрбум төгрөгийн анхаарал хандуулах зээл, 9.3 хувийг буюу 764.3 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд салбарын чанаргүй зээлийн багцыг улирал бүр үнэлэн холбогдох бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Салбарын чанаргүй зээлийн хэмжээг сүүлийн таван жилийн байдлаар авч үзэхэд 2024 оны эцсээс уул уурхайн мөчлөг, түүхий эдийн үнийн савлагаа, гадаад орчны тодорхой бус байдлаас шалтгаалан инфляцын өсөлтийг нэмэгдүүлж байгаа нь иргэдийн хэрэглээний зардал өсөж, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж, салбарын зээлийн багцын чанар муудах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хүндэтгэсэн,

ДАРГА Т.ЖАМБААЖАМЦ

9025051492 СТС5900 5043239

1518006944

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны
9 дүгээр сарын 28-ны өдрийн 1/3637 тоот
албан бичгийн хавсралт

Банк бус санхүүгийн байгуулагуудад хийсэн хяналт,
шалгалт, үр дүнгийн талаарх мэдээлэл

№	Хамрагдсан огноо	Газар дээрх хяналт шалгалт	Зайны хяналт
1	2022 он	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтаар 2022 онд Хорооны даргын баталсан удирдамжийн хүрээнд нэр бүхий 103 ББСБ-д газар дээрх хэсэгчилсэн болон бүрэн хэмжээний шалгалт, үзлэг хийж гүйцэтгэсэн. Хяналт, шалгалтын хүрээнд нэр бүхий 13 хуулийн этгээдийн хамаарал бүхий этгээдүүдэд Зөрчлийн тухай хуулийг үндэслэн зөрчлийн хэрэг нээн нийт 43.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан бол нэр бүхий 10 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн, 6 ББСБ-д улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, нэр бүхий 24 ББСБ-д шалгалтын тайлангаар хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн.	Тайлант хугацаанд салбарын нийт давхардсан тоогоор 9,086 ББСБ-ын улирлын болоод сар бүрийн тайлан мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсанд хяналт тавин ажилласан. Давхардсан тоогоор нэр бүхий 615 ББСБ-д тайлангийн хариу, тайлан мэдээг удаа дараалан алдаатай ирүүлсэн, холбогдох журам, зааврыг зөрчсөн үндэслэлээр нэр бүхий 32 ББСБ-д илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг, даалгавар хүргүүлэн биелэлтийг хангуулах талаар хяналт тавьж 83.7 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.
2	2023 он	Хорооны даргын баталсан удирдамжийн хүрээнд нийт 177 ББСБ-д газар дээрх хэсэгчилсэн шалгалт, үзлэг хийсэн. Дээрх үзлэг, шалгалтын хүрээнд нэр бүхий 28 иргэн, 9 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийг үндэслэн зөрчлийн хэрэг нээн нийт 264.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан бол нэр бүхий 10 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, нэр бүхий 2 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, нэр бүхий 3 ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны нэр төрлийг хүчингүй болгох, нэр бүхий 3 ББСБ-ын салбарын зөвшөөрлийг хүчингүй болгохоор ажлын хэсгүүдээс санал дүгнэлт гарсан.	Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 8,575 ББСБ-ын улирлын болоод сар бүрийн тайлан мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсанд хяналт тавин ажилласан. Давхардсан тоогоор нэр бүхий 1,585 ББСБ-д тайлангийн хариу хүргүүлсэн. Тайлант хугацаанд зайны хяналтын хүрээнд тайлан мэдээг удаа дараалан алдаатай ирүүлсэн, холбогдох журам, зааврыг зөрчсөн үндэслэлээр нэр бүхий 55 ББСБ-д илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг, даалгавар хүргүүлэн өгөгдсөн үүргийн биелэлт 86.3 хувьтай гүйцэтгэгдсэн.
3	2024 он	Хорооны даргын баталсан удирдамжийн хүрээнд нийт 150 ББСБ, нэгжид газар дээрх хэсэгчилсэн шалгалт, үзлэг хийсэн. Газар дээрх хяналт шалгалтын хүрээнд нэр бүхий 72 ББСБ-д шалгалтын тайлангаар хугацаатай үүрэг даалгавар	Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 9,554 ББСБ-ын улирлын болоод сар бүрийн тайлан мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсанд хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд зайны хяналтын хүрээнд

		өгч, тайлант хугацаанд үүргийн биелэлт 90.0 хувийн гүйцэтгэлтэй биелэгдсэн. Хяналт шалгалтын хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагаа болон мөнгөн зээлийн үйл ажиллагааны хууль тогтоомжийг зөрчсөн нэр бүхий 69 этгээдэд Зөрчлийн тухай хуулийг үндэслэн нийт 469.2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан бол нэр бүхий 2 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, нэр бүхий 3 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны 2 нэр төрлийг түдгэлзүүлэх, нэр бүхий 8 ББСБ-ын салбарын зөвшөөрлийг хүчингүй болгохоор ажлын хэсгүүдээс санал дүгнэлт гаргасан.	тайлан мэдээг удаа дараалан алдаатай ирүүлсэн, холбогдох журам, зааврыг зөрчсөн үндэслэлээр нэр бүхий 34 ББСБ-д илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага, нэр бүхий 302 ББСБ-д цахим хаягаар нь мэдэгдэл хүргэн хугацаатай үүрэг, даалгавар өгөгдсөн бөгөөд үүргийн биелэлтийг тооцон ажилласан.
4	2025 он	Хорооны даргын баталсан удирдамжийн хүрээнд нийт 601 ББСБ-д газар дээрх шалгалт, үзлэг хийсэн. 48 ББСБ-д Зөрчлийн тухай хуулийн дагуу 850.0 төгрөгийн торгууль ногдуулан 87.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.	Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 13,067 зохицуулалттай этгээдийн буюу үүнээс 10,923 ББСБ-ын улирлын болоод сар бүрийн тайлан мэдээг хүлээн авч хянан баталгаажуулсан. Тайлант хугацаанд зайны хяналтын хүрээнд тайлан мэдээг удаа дараалан алдаатай ирүүлсэн, холбогдох журам, зааврыг зөрчсөн үндэслэлээр нэр бүхий 26 ББСБ-д илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага, нэр бүхий 291 ББСБ-д цахим хаягаар нь мэдэгдэл хүргэн хугацаатай үүрэг, даалгавар өгөгдсөн бөгөөд үүргийн биелэлтийг тооцсон.
5	2026.II улирал	Тайлант хугацаанд нэр бүхий 52 ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажилласан.	Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор тайлан мэдээг ирүүлвэл зохих 6,518 зохицуулалттай этгээдээс 5,717 ББСБ-ын улирлын болоод сар бүрийн тайлан мэдээг хүлээн авч хянан баталгаажуулсан, ажилласан. Тайлант хугацаанд зайны хяналтын хүрээнд тайлан мэдээг удаа дараалан алдаатай ирүүлсэн, холбогдох журам, зааврыг зөрчсөн үндэслэлээр нэр бүхий 25 ББСБ-д илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага, нэр бүхий 12 ББСБ-д албан бичгээр тайлангийн хариу, нэр бүхий 53 ББСБ-д цахим хаягаар нь мэдэгдэл хүргэн хугацаатай үүрэг, даалгавар өгөгдсөн бөгөөд үүргийн биелэлтийг тооцон ажилласан.

.....oOo.....